

3. Олон нийтийн ажилд идэвхи, санаачлага гарган бусдыгаа манлайлан оролцдог байх.
4. Оролцооны клуб, бүлэг дугуйлан секц хамрагдсан байх.
5. Удирдан чиглүүлж манлайлдаг байх

3.1.8 Сумын “Мянгат малчин” батламж

1. Мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж удам гарвал, ашиг шимийг тогтоосон, стандартын шаардлага хангасан эцэг малыг үржилд ашигладаг
2. Малаа сумын хөдөө аж ахуйн тасгийн бүртгэлд бүртгүүлсэн
3. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэж, цагаан идээ боловсруулах зэргээр ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутагтаа ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан
4. Малаа мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамруулсан, малыг алс оторлох, нүүдэл хийхдээ сумын мал эмнэлгийн нэгжийн эмчээр мал эмнэлгийн үзлэг хийлгэсэн, малын эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ авч хэвшсэн.
5. Малын тоо толгой нь 1000 хүрсэн малчин өрхөд “Батламж” олгоно

3.1.9 Сумын “Соёлын биет бус өвлөн уламжлагч”

3.9.1 Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын арга ухаан, соёлын өвийн олон төрлийг өвлөн уламжлагч байна.

3.9.2 Сумын Соёлын төвийн өв тээгчийн бүртгэлд орсон, тухайн өвийг мэдлэг ухаан, ур чадвар, арга барилын хувьд язгуур шинж чанараар нь маш сайн, өндөр түвшинд өвлөн уламжилж, эзэмшсэн, мэдлэгээ хувь хүн, ах дүү, төрөл садан бүхий ард иргэдэд өвлөн уламжилж түгээн дэлгэрүүлж байгаа

3.9.3 Улс бүсийн уралдаан тэмцээнд оролцож амжилт гаргасан байна.

ДӨРӨВ. СУМЫН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ

4.1 Шагналд нэр дэвшигч нь Журмын гуравдугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

4.2 Сумын Засаг даргын шагналаар шагнуулах санаачилгыг сум, орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гаргана.

4.3 Сумын Засаг даргын “Баярын бичиг” Оны “Тэргүүний ажилтан” шагналд нэр дэвшүүлэхээр тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.Үүнд:

4.3.1 Нэр дэвшигчийн анкет

4.3.2 Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт

4.3.3 Хамт олны хурлын тэмдэглэл

4.3.4 Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн харьяалах төр болон төрийн бус байгууллагын албан бичиг

Шагналд нэр дэвшсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын үр дүн гаргасан зүтгэл, тухайн салбар, байгууллагын ажлын амжилтанд оруулсан хувь нэмэр нь тодорхой бөгөөд холбогдох судалгаа, тооцоогоор батлагдсан, байгууллагын дарга гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулсан байна.

4.4 “Оны онцлох байгууллага” шагналд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.Үүнд:

4.4.1 Байгууллагын товч танилцуулга

4.4.2 Байгууллагын тайлан /уг тайлан шагналын шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлаарх байгууллагын гаргасан амжилт, ололтын талаар баримтжуулсан байна.

4.5 Сумын Засаг даргын “Баярын бичиг” шагналд нэр дэвшигчдийн материалыг тухайн тэмдэглэлт өдрөөс ажлын 15 хоногийн өмнө сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн байх шаардлагатай.

4.6 Сумын “Аварга малчин”, “Мянгат малчин”- аар тодорхойлохдоо дараах бичиг баримт бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.6.1 Малчны товч анкет

4.6.2 Хөдөө аж ахуйн газрын тодорхойлолт газар дээр нь шалгасан дүгнэлт

4.6.3 Багийн Засаг даргын хүсэлт

4.7 Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4- д заасан болзол хангасан уяачид “Сумын Алдарт уяач” цол олгуулах хүсэлтийг

холбогдох баримт бичгийн бүрдүүлэн сумын уяачдын холбооноос жил бүрийн 01 сарын 25 ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

ТАВ. СУМЫН ШАГНАЛААР ШАГНАХ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ОЛГОХ

5.1 Энэхүү журмаар зохицуулагдсан шагналаар шагнах асуудлыг Багийн засаг дарга, байгууллагын удирдлагын тодорхойлолт болон саналыг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Үүнд:

5.1.1 Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-д нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 01 сарын 25-ны өдрийн дотор

5.1.2 Сумын “Оны тэргүүний ажилтан”, “Оны онцлох байгууллага”, “Сумын Тэргүүний сурагч”- д нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 20 -ны өдрийн дотор

5.1.3 Сумын Засаг даргын “Баярын бичиг”-ээр шагнах асуудлыг тухай бүр

5.2 Сумын Засаг даргын Баярын бичиг шагналыг Засаг Даргын тамгын газар, “Оны онцлох байгууллага”, “Оны тэргүүний ажилтан”, “Сумын Аварга малчин”, “Сумын алдарт уяач”, Сумын “Тэргүүний газар тариаланч”, Сумын “Тэргүүний сурагч”, “Сумын Мянгат малчин”, Сумын “Соёлын биет бус өв өвлөн уламжлагч” шагналыг Тамгын газрын холбогдох мэргэжилтнүүд Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.3 Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-ийн шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд малчид, уяачдад гардуулан өнгө.

5.4 “Оны тэргүүний ажилтан”, “Оны онцлох байгууллага”, “Оны тэргүүний сурагч”, Сумын “Тэргүүний газар тариаланч”-ийн шагналыг сумын Шинэ жилийн арга хэмжээн дээр гардуулна.

5.5 Сумын “Соёлын биет бус өв өвлөн уламжлагч” шагналыг сумын Баяр наадмын арга хэмжээн дээр гардуулна.

5.6 Сумын Засаг даргын шагналд дагалдах мөнгөн шагнал болон үнэ бүхий зүйлийн мөнгөний хэмжээ, олгох хугацаа

№	Шагналын нэр	Олгох шагналын хэмжээ	Шагнах хугацаа
1	Сумын “Оны онцлох байгууллага” өргөмжлөл	200000 төгрөг	Шинэ жил
2	Сумын “Оны тэргүүний ажилтан”	100000 төгрөг	Шинэ жил
3	Сумын Засаг даргын “Баярын бичиг”	30000 төгрөг	Тухай бүр

4	Сумын “Аварга малчин өрх”	200000 төгрөг	Цагаан сар
5	Сумын “Алдарт уяач”	100000 төгрөг	Цагаан сар
6	Сумын “Тэргүүний тариаланч”	100000 төгрөг	Шинэ жил
7	Сумын “Тэргүүний сурагч”	50000 төгрөг	Шинэ жил
8	Сумын “Мянгат малчин”	50000 төгрөг	Цагаан сар
9	Соёлын биет бус өв өвлөн уламжлагч	100000 төгрөг	Наадам

6.6 Шагналд зарцуулагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулна.

ЗУРГАА. БУСАД

6.1 Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргын шагналаар шагнагдсан иргэдийн талаар мэдээллийн сантай байх ба санг шагналын төрөл, олгосон хугацаа, огноогоор төрөлжүүлсэн байна.

6.2 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөн болон сумын Засаг даргын шагналд тодорхойлж ирүүлсэн шагналын материалуудыг буцаан хүргүүлэх болон шагнагдагсдын материалыг оны эцэст архивт хүлээн өгөх ажлыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

№	Шагналын төрөл	Шагналын хэмжээ	Цагаан сар
1	Сумын “Аварга малчин өрх”	200000 төгрөг	Цагаан сар
2	Сумын “Алдарт уяач”	100000 төгрөг	Цагаан сар
3	Сумын “Тэргүүний тариаланч”	100000 төгрөг	Шинэ жил